



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар A/296

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, хуулийн этгээд “Идэр нумт” ХХК /РД:4125827/-ийн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/294, 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/295 дугаар захирамжаар Мөрөн 8 дугаар баг Ширэндэв-1, 115а тоотод байршилтай 6712016736 нэгж талбарын дугаартай 1862м², 6712016738 нэгж талбарын дугаартай 1247м² үйлчилгээтэй орон сууцны зориулалт бүхий 2 нэгж талбариудын газруудыг нэгтгэж 3109м² гэж өөрчилж, үлдсэн 27 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/294, 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/295 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгосугай.

3. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа хуулийн этгээд “Идэр нумт” ХХК /РД:4125827/-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүүл) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдеж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН